



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/399

Улаанбаатар хот

“Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын  
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1105 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэгдсэн нийт 61 001 569 /жаран нэгэн сая нэг мянган таван зуун жаран есөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий JEA-800 маркийн 54-41 УББ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ / Г.Төмөрбаатар / -д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг актлан сэлбэгийн зориулалтаар фондолж, ашиглалтын шаардлага хангахгүй болон илүүдэлтэй сэлбэгүүдийг хоёрдогч түүхий эд, сэлбэгийн зориулалтаар 500 000 /таван зуун мянган/ төгрөгнөөс доошгүй үнээр худалдан борлуулж зохих дансанд нь орлого болгон авахыг “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ / Г.Төмөрбаатар / -д үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ / Г.Төмөрбаатар / -д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /М.Мандах/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050001151